



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Нийгмийн даатгалын сангийн авлагад суутган тооцож хөрөнгө хүлээн авах тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн А-96 дугаар тушаалаар “Капитал банк” ХХК-ийг албадан татан буулгахаар шийдвэрлэж, мөн өдрийн тушаалаар Банкны эрх хүлээн авагч томилж, Эрх хүлээн авагч нь банкны хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, хамгаалах, худалдан борлуулах, иргэд болон төрд учирсан хохирлыг барагдуулахаар ажиллаж байна.

Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар /Нийгмийн даатгалын сан/ татан буугдсан Капитал банкинд хадгалагдаж байсан хугацаатай мөнгөн хадгаламж, хуримтлагдсан хүүгийн нийт 103,199,998,500.00 /нэг зуун гурван тэрбум нэг зуун ерэн есөн сая есөн зуун ерэн найман мянга таван зуун/ төгрөгийг гаргуулахаар Банкны тухай хуулийн 71.1-д заасны дагуу банкны Эрх хүлээн авагчид хандан нэхэмжлэл гаргаж, авлагыг баталгаажуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 2.8-д зааснаар “Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Банкны эрх хүлээн авагч нартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, татан буугдсан банкны чанаргүй активыг шуурхай барагдуулах, төлбөрт хураагдсан үл хөдлөх эд хөрөнгө болон улсын орлогод хураагдсан эд хөрөнгөөс олсон орлогыг эдийн засгийн эргэлтэд оруулж, эмнэлэг, сургууль, улсын хэрэгцээнд ашиглах” талаар шуурхай арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан.

Энэ ажлын хүрээнд Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн зүгээс үл хөдлөх хөрөнгийг татан буугдсан Капитал банкнаас төлөх өр төлбөрийн зарим хэсэгт тооцож, шилжүүлэн өгөх тухай саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.

13202039

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1.Нийгмийн даатгалын сангийн Капитал банкин дахь хугацаатай мөнгөн хадгаламжийн авлагын зарим хэсэгт тооцож тус Банкны эрх хүлээн авагчаас санал болгосон үл хөдлөх хөрөнгийг хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шилжүүлэн авахыг зөвшөөрөв.

2."Хүлээн авсан хөрөнгийг Нийгмийн даатгалын сангийн эргэлтийн хөрөнгийн "борлуулах зориулалттай үндсэн хөрөнгө" дансанд бүртгэж, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, орлогыг Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх нь зүйтэй " гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

